



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/69

Дуурсах

Дам тамхидалтын эсрэг
аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 20.2.5 дахь заалт, Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Дам тамхидалтын эсрэг аян”-ыг 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэл 3 сарын хугацаанд зохион байгуулсугай.
2. Үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Аяны үйл ажиллагааг удирдамж, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Ууганцэцэг)-т үүрэг болгосугай.
4. Үйл ажиллагаанд шаардагдах 768.000 (Долоон зуун жаран найман мянган төгрөг)-ийг төсөл, хөтөлбөрийн арга хэмжээний зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.



ДАРГА *Хажидсүрэн* ЭНХЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
08 дугаар сарын 03 ны өдрийн
А/6 дугаар тушаалын хавсралт

УДИРДАМЖ



“Дам тамхидалтын эсрэг аян” зохион байгуулах тухай

2022 оны 08 дугаар сарын 03

Дуурсах

Нэг. Үндэслэл:

Монгол улс халдварт бус өвчний тархалтаараа дэлхийд хоёрдугаарт ордог бөгөөд энэ нь хүн амын дундах нас баралтын зонхилох хувийг эзэлж байна.

Зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин зэрэг нас баралтын гол шалтгаан болдог өвчнүүд тамхидалтаас үүдэлтэй. Иймд эдгээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, өсвөр үе, хүүхэд залуучуудад тамхины хор уршгийг мэдээлэх, таниулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хоёр. Зорилго:

Хүн амын дундах тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас өсвөр үе, хүүхэд залуучуудыг хамгаалах, тамхины хор уршиг, эдийн засагт сөргөөр нөлөөлөх нөлөөллийн тухай иргэдэд таниулах, тамхинаас гарах иргэдийн тоог нэмэгдүүлэх, дам тамхидалтад өртөх эрсдэлийг бууруулахад оршино.

Гурав. Зорилт:

- Иргэдийн тамхидалтын эсрэг хүүхэд-хүүхэд, иргэд-гэр бүл, хамт олон-хамт олондоо нөлөөлөх оролцоог нэмэгдүүлэх;
- Иргэд, өсвөр үе, хүүхэд залуучуудын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлж, тамхины хор уршгийн талаарх ойлголтыг сайжруулах;
- Тамхидалтын эсрэг уриалсан уралдаан тэмцээн зохион байгуулах;

Дөрөв. Хамрах хүрээ:

- Баянхонгор аймгийн төрийн болон төрийн бус байгууллага;
- Өсвөр үе, хүүхэд залуучууд;
- Иргэд, олон нийт;

Тав. Үйл ажиллагаа:

- Тамхины хор нөлөөллийн талаарх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг өсвөр үе, хүүхэд залуус, иргэдэд танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулах, сурталчлах;

Төрийн болон төрийн бус байгууллага алба хаагч, үйлчлүүлэгч нартаа тамхины хор уршгийн талаар сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах;

Зургаа. Зохион байгуулах хугацаа:

2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийг дуустал

Долоо. Тайлан ирүүлэх:

Аж ахуй нэгж, байгууллага, сум өрхийн Эрүүл мэндийн төвүүд, аяны хүрээнд хийсэн ажлын тайланг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн дотор Нийгмийн эрүүл мэндийн төвд ирүүлнэ.

Найм аяныг дүгнэх :

2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирсэн тайлангуултай танилцаж ажлын хэсэг хуралдаж доорхи үзүүлэлтийн дагуу дүгнэнэ.

-Байгууллагын болон иргэдэд тамхины талаарх хийсэн сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо, гарын авлага шторк хүрсэн иргэдийн тоо

Тамхинаас гарсан иргэдийн тоо

Тамхи татах цэгтэй эсэх,


ЕС.Шагнал урамшуулал:

Аяны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон 3 байгууллагад өргөмжлөл үнэ бүхий зүйл олгоно.

Арав. Үр дүн:

- Тамхины хор нөлөөлөл, тамхины хяналтын тухай хуулийн талаарх иргэдийн ойлголт нэмэгдэж, олон нийтийн газарт ил, задгай тамхи татах иргэдийн тоо буурсан байна.
- Хүн амын дунд зонхилон тохиолддог тамхинаас үүдэлтэй халдварт бус өвчлөлөөс сэргийлж, дам тамхидалтад өртөх эрсдэлийг бууруулсан байна.
- Тамхигүй хамт олон, тамхинаас татгалзсан иргэдийг сурталчилж, тамхинаас татгалзах шийдвэр гаргагч нарт урам зориг олгоно.
- Тамхидалтаас өсвөр үе, хүүхэд залуучуудыг хамгаалж, дам тамхидалтад өртөх эрсдэлийг бууруулна.


Эрүүл мэндийн газрын даргын ²⁰²² /.../ оны
 08 дугаар сарын 05 ны өдрийн
 А/С/ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ДАМ ТАМХИДАЛТЫН ЭСРЭГ АЯНЫ ҮЙЛ
 АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Зохион байгуулах үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах эзэн, байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	2	3	4	5	6
1	Аяны хүрээнд төлөвлөгөө боловсруулан батлуулах	Төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, тайланг хугацаанд нь ирүүлэх	2022.08.08 -11.08	ЭМГ НЭ, ЗӨСТ СӨЭМТ-үүд,	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
2	Дам тамхидалтын эсрэг нөлөөллийн сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг иргэдэд зохион байгуулах	Дам тамхидалтын хор уршгийн талаарх мэдээллийг хүн амын 30 хувьд хүргэсэн байна.	2022.08.08 -11.08	ЭМГ, НЭ, ЗӨСТ СӨЭМТ-үүд,	Сумдын ЗДТГ, БШУГ, ЕБС
3	Тамхины эсрэг ухуулга таниулга сайн дурын хүүхэд залуус, иргэд, алба хаагчдыг татан оролцуулах, тэдгээрийг сурталчлах	Хамрагдсан хүүхэд залуу, иргэд, алба хаагчдын тоо, хувь	2022.08.08 -11.08	Төрийн байгууллагууд	Бүх шатны төрийн байгууллагууд
4	Тамхины эсрэг видео шторк бэлтгэн түгээх	Бэлтгэсэн шторкын тоо, хандалтын тоо	2022.08.08 -11.08	ЭМГ, НЭ, ЗӨСТ СӨЭМТ-үүд	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
5	Тамхидалтын эсрэг уриа, постер, гарын авлага бэлтгэн түгээх	Гарын авлага, зурагт хуудас тараасан иргэдийн тоо, Цахим орчинд хүрсэн хандалтын тоо,	2022.08.08 -11.08	ЭМГ, НЭ, ЗӨСТ СӨЭМТ-үүд	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
6	Дам тамхидалтын эсрэг хүүхэд залуус, иргэдийн дунд танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээн зохион байгуулах, сурталчлах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Оролцсон иргэдийн тоо	2022.08.08 -11.08	ЭМГ, НЭ, ЗӨСТ СӨЭМТ-үүд,	БШУГ, Сумдын ЗДТГ, ЕБС
7	Албан байгууллагууд тамхи татдаг ажилтан, алба хаагчдын судалгааг гаргаж, тэдгээрт чиглэсэн сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	Судалгаанд хамрагдсан алба хаагчдын тоо, тамхинаас гарсан алба хаагчдын тоо, тайлан	2022.08.08 -11.08	ЭМГ, Төрийн байгууллагууд	Бүх шатны төрийн байгууллагууд

Эрүүл мэндийн газрын даргын ... оны
08 дугаар сарын 05 ны өдрийн
А/69 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**ДАМ ТАМХИДАЛТЫН ЭСРЭГ АЯН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	2	3	4	5	6
1	Өргөмжлөл	ш	9	22000	198.000
2	Үнэ бүхий зүйл (Алтан хонх тэмцээн)	ш	3	50.000	150.000
3	Үнэ бүхий зүйл (Гар зургийн уралдаан)	ш	3	40000	120.000
4	Үнэ бүхий зүйл (Тамхигүй байгууллага, хамт олон шалгаруулах)	ш	3	100.000	300.000
					Нийт 768.000

_____оОо_____

8	Тамхидалтгүй байгууллага, хамт олон шалгаруулах	Тамхины хор уршгийн сургалт, нөлөөллийн ажлын тоо, хамрагдсан иргэдийн тоо, тамхинаас гарсан алба хаагчдын тоо Тамхины цэгтэй эсэх	2022.11.20	ЭМГ, СӨЭМТ- ҮҮД.	Бүх шатны төрийн байгууллагууд
---	-------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------	---------------------	--------------------------------------

_____оОо_____